# “МОНГОЛ ОРНЫ ТУСГАЙ ХАМГААЛАЛТТАЙ ГАЗАР НУТГИЙН СҮЛЖЭЭНИЙ ХЭМЖЭЭНД МЭДЭЭЛЛИЙН САНГ СТАНДАРТЫН ДАГУУ БАЙГУУЛАХ”

# ЗӨВЛӨХ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ТАЙЛАН




Захиалагч байгууллага:

БАЙГАЛЬ ОРЧИН, УУР АМЬСГАЛЫН ӨӨРЧЛӨЛТИЙН ЯАМ (БОУАӨЯ)

Санхүүжүүлэгч байгууллага:

ХОЛБООНЫ БҮГД НАЙРАМДАХ ГЕРМАН УЛСЫН СЭРГЭЭН БОСГОЛТ ЗЭЭЛИЙН БАНК (KFW)

Гүйцэтгэгч байгууллага:

БИТСОФТ ХХК

**Улаанбаатар**

**2025 оны 04 дүгээр сарын 08**

# Агуулга


**1. Зөвлөх үйлчилгээний мэдээлэл 2**
**2. Зөвлөх үйлчилгээний зорилго 2**
**3. Зөвлөх үйлчилгээний баг, ажлын төлөвлөгөө 2**
**4. Зөвлөх үйлчилгээний гүйцэтгэл 10**
**5. Зөвлөх үйлчилгээний дүгнэлт ба зөвлөмж 70**

# 1. Зөвлөх үйлчилгээний мэдээлэл

Битсофт ХХК нь Байгаль орчин, уур амьсгалын яамтай 2024 оны 05 дугаар сарын 22-ны өдөр “Монгол орны тусгай хамгаалалттай газар нутгийн сүлжээний хэмжээнд мэдээллийн санг стандартын дагуу байгуулах” 24/174 дугаартай зөвлөх үйлчилгээний гэрээг байгуулсан.

Тус гэрээний хүрээнд 2024 оны 05 дугаар сарын 22-ны өдрөөс 2025 оны 04 дүгээр сарын 03-ны өдөр хүртэл хийгдсэн ажлын гүйцэтгэлийг тус эцсийн тайланд тусгасан болно.

# 2. Зөвлөх үйлчилгээний зорилго

Энэхүү зөвлөх үйлчилгээний зорилго нь Монгол орны тусгай хамгаалалттай газар нутгийн (ТХГН) сүлжээний хэмжээнд мэдээллийн санг стандартын дагуу бий болгож, www.mpa.gov.mn болон 41 хамгаалалтын захиргаа (ХЗ)-ны цахим хуудсыг шинэчлэн сайжруулах, байнгын ажиллагаанд оруулах, мөн БОУАӨЯ-ны цахим болон цаасан архивын нэгж үүсгэх, цаашид байгууллагын үйл ажиллагааг тасралтгүй, ил тод, нээлттэй, түргэн шуурхай явуулах нөхцөлийг бүрдүүлэхэд оршино.

Ингэснээр Монгол орны ТХГН-ийн эдийн засаг, нийгэм, байгаль орчин, тэр дундаа экосистемийн болон биологийн олон янз байдлыг хамгаалах, тогтвортой аялал жуулчлалыг хөгжүүлэх, орчны бүсийн хүн амын амьжиргааг дэмжихэд үзүүлж буй үр нөлөөг олон нийт, аялал жуулчлалын байгууллагуудад сурталчлах, ТХГН-ын хамтын менежментийг хөгжүүлэн өргөжүүлэх, ТХГН-ийн менежментийг сайжруулахад гадаадын болон дотоодын хөрөнгө оруулалтыг татахад дэмжлэг үзүүлэх болно.

# 3. Зөвлөх үйлчилгээний баг, ажлын төлөвлөгөө

Багт дараах мэргэжилтнүүд чиг үүргийн дагуу ажиллав.

### 3.1 Багийн зохион байгуулалт, үүрэг хариуцлага

| 1. Техникийн болон удирдах ажилтнууд | | |
|---|---|---|
| **Нэр** | Албан тушаал | Хариуцах ажил |
| **Жагсалаг Айжан** | Төслийн менежер | • Зөвлөх үйлчилгээний удирдлага, төлөвлөлт |

| | | |
|---|---|---|
| | | ● Төсөл хэрэгжүүлэх<br>● Төсөл хүлээлгэн өгөх<br>● Төслийн бизнес дүн шинжилгээ<br>● Харилцаа хамтын ажиллагаа |
| **Цэлмэгмаа Цэрэнтогтох** | Төслийн зөвлөх | ● Системийн архитектур зохион байгуулалт<br>● Зөвлөх үйлчилгээний менежмент<br>● Front-end хөгжүүлэлт |
| **Батзориг Мөнгөнбагана** | Ахлах хөгжүүлэгч | ● Системийн Backend хөгжүүлэлт<br>● Front-end хөгжүүлэлт<br>● Суурь кодчилол |

***Хүснэгт 1****. Зөвлөх үйлчилгээний баг*

| 2. Туслах ажилтнууд | | |
|---|---|---|
| **Нэр** | Албан тушаал | Хариуцах ажил |
| **Даваасамбуу Эрдэнэцогт** | Систем инженер | ● Сервер болон тоног төхөөрөмж, дэд бүтэц<br>● Сүлжээний архитектур<br>● Мэдээллийн аюулгүй байдал<br>● Хяналт мониторинг<br>● Автоматжуулалт болон нөөцлөлт |
| **Болдбаатар Ариунболд** | UI Designer & Хөгжүүлэгч | ● Системийн загвар<br>● Front-end хөгжүүлэлт |
| **Цагаан-Өвгөн Цэрэнбаатар** | Хөгжүүлэгч | ● Сервер болон тоног төхөөрөмж, дэд бүтэц<br>● Сүлжээний архитектур<br>● Мэдээллийн аюулгүй байдал<br>● Хяналт мониторинг<br>● Автоматжуулалт болон нөөцлөлт |
| **Баярмаа Долгормаа** | Апп хөгжүүлэгч | ● Сервер болон тоног төхөөрөмж, дэд бүтэц<br>● Сүлжээний архитектур<br>● Мэдээллийн аюулгүй байдал<br>● Хяналт мониторинг<br>● Автоматжуулалт болон нөөцлөлт |

| | | |
|---|---|---|
| **Жаргалсайхан Доржбат** | Хөгжүүлэгч | ● Сервер болон тоног төхөөрөмж, дэд бүтэц<br>● Сүлжээний архитектур<br>● Мэдээллийн аюулгүй байдал<br>● Хяналт мониторинг<br>● Автоматжуулалт болон нөөцлөлт |
| **Мандах Ананд** | Апп хөгжүүлэгч | ● Сервер болон тоног төхөөрөмж, дэд бүтэц<br>● Сүлжээний архитектур<br>● Мэдээллийн аюулгүй байдал<br>● Хяналт мониторинг<br>● Автоматжуулалт болон нөөцлөлт |
| **Хутаг-Өндөр Мөнхбаяр** | Хөгжүүлэгч | ● Сервер болон тоног төхөөрөмж, дэд бүтэц<br>● Сүлжээний архитектур<br>● Мэдээллийн аюулгүй байдал<br>● Хяналт мониторинг<br>● Автоматжуулалт болон нөөцлөлт |

***Хүснэгт 2***. *Зөвлөх үйлчилгээний баг*

### 3.2 Зөвлөх үйлчилгээний гүйцэтгэх ажлын төлөвлөгөө тайлагнах хуваарь

| Үйл ажиллагаа | **1-р сар** | | | | **2-р сар** | | | | **3-р сар** | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| Долоо хоног | **1** | **2** | **3** | **4** | **1** | **2** | **3** | **4** | **1** | **2** | **3** | **4** |
| Хэрэглэгчийн шаардага тодорхойлох | | | | | | | | | | | | |
| Үйл ажиллагааны зураглал гаргах | | | | | | | | | | | | |
| Зөвлөх үйлчилгээний дизайн боловсруулах | | | | | | | | | | | | |
| Ерөнхий архитектур боловсруулах | | | | | | | | | | | | |
| Дэд системүүдийн ерөнхий бүтцийг тодорхойлох | | | | | | | | | | | | |
| Өгөгдлийн сангийн загвар боловсруулах | | | | | | | | | | | | |
| Захиалагчтай тогтмол харилцах | | | | | | | | | | | | |

| | | | | | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| Хөгжүүлэлт | | | | | | | | | | | | |
| Бусад системүүдтэй холболт | | | | | | | | | | | | |
| Туршилт, нэвтрүүлэлийн ажлууд | | | | | | | | | | | | |
| Гарын авлага бэлдэх | | | | | | | | | | | | |
| Нэвтрүүлэх | | | | | | | | | | | | |
| Сургалт | | | | | | | | | | | | |
| Тайлан | | | | | | | | | | | | |
| Хүлээлгэн өгөх | | | | | | | | | | | | |

***Хүснэгт 3**. Зөвлөх үйлчилгээний тайлагнах хуваарь*

### 3.3 Ажлыг дуусгаж тайлан өгөх

| **Тайлан** | **Гэрээ хийгдсэн өдрөөс хойш** |
|---|---|
| 1. Эхлэлийн тайлан | 8 дахь долоо хоног |
| 2. Эцсийн тайлан | 12 дахь долоо хоног |

***Хүснэгт 4**. Зөвлөх үйлчилгээний тайлан өгөх хуваарь*

### 3.4 Ажиллах хүчний ажиллах хуваарь

| Нэр | Албан тушаал | **Сар (хөндлөн зураасаар тэмдэглэх)** | | | | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | **1-р сар** | | | | **2-р сар** | | | | **3-р сар** | | | |
| | | **W1** | **W2** | **W3** | **W4** | **W1** | **W2** | **W3** | **W4** | **W1** | **W2** | **W3** | **W4** |
| Ж.АЙЖАН | Төслийн менежер | | | | | | | | | | | | |
| Ц. ЦЭРЭНТОГТОХ | Төслийн зөвлөх | | | | | | | | | | | | |
| Б.МӨНГӨНБАГАНА | Ахлах Хөгжүүлэгч | | | | | | | | | | | | |
| Д. ЭРДЭНЭЦОГТ | Систем инженер | | | | | | | | | | | | |
| Б. АРИУНБОЛД | Ui Designer, Хөгжүүлэгч | | | | | | | | | | | | |
| Ц. ЦЭРЭНБААТАР | Хөгжүүлэгч | | | | | | | | | | | | |

| | | | | | | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| Б. ДОЛГОРМАА | Апп хөгжүүлэгч | | | | | | | | | | | | |
| Ж. ДОРЖБАТ | Хөгжүүлэгч | | | | | | | | | | | | |
| М. АНАНД | Апп хөгжүүлэгч | | | | | | | | | | | | |
| Х. МӨНХБАЯР | Хөгжүүлэгч | | | | | | | | | | | | |

***Хүснэгт 5****. Ажиллах хүчний хуваарь*

| | |
|---|---|
| | Системийн шинжилгээ болон загварчлал, зөвлөх үйлчилгээний удирдлага |
| | Зөвлөх үйлчилгээний тайлан |
| | Сургалт, Гарын авлага, сургалтын материал бэлтгэх |
| | Системийн хөгжүүлэлт, програмчлал |
| | Загвар дизайн |
| | Системийн турших, програмын алдааг засах |

***Хүснэгт 6****. Өнгөний мэдээлэл*

**Үндсэн ажилтнаар:** <u>**10**</u> **Цагийн ажилтнаар:** 0

**Тайлангийн тоо:** <u>**2**</u>

**Гүйцэтгэх хугацаа:** 90 хоног

### 3.5 Хийгдэх ажлын жагсаалт

| **Хийгдэх ажлын жагсаалт** | **Гүйцэтгэх хугацаа (90 хоног)** | | |
|---|---|---|---|
| | **1-30 хоног** | **31-60 хоног** | **61-90 хоног** |
| **I. Бэлтгэл ажил, технологийн шинэчлэл** | | | |

| | | | |
|---|---|---|---|
| 1. Одоо ажиллаж буй ТХГН-ийн сүлжээний нэгдсэн цахим хуудас www.mpa.gov.mn-г шинэчилж технологи болон ашиглагдаж буй фреймворкийг хувилбар ахиулж сайжруулах | ✓ | ✓ | |
| 17. Системийн UX талыг сайжруулах үүднээс /Angular, React, Vue/ гэх мэт Frontend framework-уудын аль нэгийг ашиглан SEO-д харшлахгүйгээр хэрэгцээтэй модулиуд дээр SPA хэлбэрээр ажилладаг байх | ✓ | ✓ | |
| 5. Монгол орны ТХГН-ийн сүлжээний нэгдсэн цахим хуудас болон 41 ХЗ-ны цахим хуудасны домайн нэр, түүний эрх, багадаа 5 и-мэйл хаягтай байх | ✓ | | |
| 29. Улсын ТХГН мэдээллийн сан болон Орон нутгийн ТХГН-ын мэдээллийн сан серверийн байршлыг Цаг Уурын Хүрээлэнгийн серверээс шилжүүлэн байршуулах | ✓ | | |
| **II. Хөгжүүлэлтийн ажил** | | | |
| 2. Монгол орны ТХГН-ийн сүлжээний нэгдсэн цахим хуудас болон 33 ХЗ-ны цахим хуудсуудыг динамик хэлбэрээр, түүнд мэдээлэл оруулах, хянан засварлах боломжтойгоор хийх | ✓ | ✓ | |
| 3. Нэмэлтээр 8 ХЗ-ны цахим хуудсыг нэгдсэн стандартын дагуу боловсруулах | | ✓ | |
| 4. Монгол орны ТХГН-ийн сүлжээний нэгдсэн цахим хуудас нь 41 ХЗ, олон улсын байгууллагуудын болон тэдгээрийн хэрэгжүүлж буй төсөл, хөтөлбөрүүдийн цахим хуудсуудтай холбогдсон байх | | ✓ | ✓ |
| 6. Бүх цахим хуудсууд нь Монгол, Англи хэл дээр хийгдэх /шаардлагатай орчуулгыг админ хэсгээс засварлах боломжтой байх/ | | ✓ | ✓ |
| 18. Цахим хуудас дотор хайлтын системтэй байх | | ✓ | |
| 20. Цахим хуудсууд нь фото зураг, видео болон аудио бичлэг оруулах, хадгалах хэсэгтэй байх | | ✓ | |
| 21. Цахим хуудсанд нийтлэгдсэн контентыг олон нийтийн сүлжээнд мэдээллийг хуваалцах болон түгээх боломжтой байх | | ✓ | |
| 22. Мөн pdf, xsl, word файлаар хадгалагдсан материалууд (тайлан, илтгэл, диаграмм)-ыг оруулах, хадгалах хэсэгтэй байх | | ✓ | |
| 33. ТХГН-н удирдлагууд тусдаа sub domain бүхий танилцуулга хэсэгтэй байх | | ✓ | ✓ |

| | | | |
|---|---|---|---|
| **III. Интеграцийн ажил** | | | |
| 8. EIC.mn сервер дээр байршиж буй БИОСАН зэрлэг амьтан, ургамлын мониторингийн мэдээллийн сангийн серверийг одоогийн хөгжүүлж буй сервер рүү шилжүүлэх | ✓ | ✓ | |
| 10. БИОСАН-гийн дашбоард олон нийтэд харагдаж байх, Монгол улсын хэмжээнд хаана хэрэглэгдэж байгаа харагдах, мөн тусгай хамгаалалттай газрын ангилал бүрээр харьцуулан харагдах | | ✓ | ✓ |
| 11. СМАRT-ын дашбоард олон нийтэд харагдаж байх, Монгол улсын хэмжээнд хаана хэрэглэгдэж байгаа харах | | ✓ | ✓ |
| 12. ТХГН-ийн менежментийн үр ашигт байдлын үнэлгээний дашбоард олон нийтэд харагдаж байх | | ✓ | ✓ |
| 13. Орон зайн /Газрын зураг/ мэдээллийг оруулж олон нийтэд ойлгомжтой хүртээмжтэй харагддаг байх | | ✓ | ✓ |
| 14. Орон зайн мэдээллийг баяжуулж харагдах давхарга болон бусад мэдээллийг харах боломжийг олгох | | ✓ | ✓ |
| 15. ТХГН-т хийх аялал жуулчлал болон үйл явдлын мэдээллийг олон нийтэд хүртээмжтэй байдлаар зохиомжлон цахим хуудсанд оруулах | | ✓ | ✓ |
| 16. ТХГН-н удирдлага өөрсдийн цахим хуудсанд жуулчлал, тухайн газар болох эвент, үйл явдлын мэдээллийг нийтлэх боломжтой болгох | | ✓ | ✓ |
| 30. MPA.GOV.MN нэгдсэн сайт дээр бусад системүүд рүү хандах хандалтын холбоосуудыг байршуулах | | ✓ | ✓ |
| 31. ТХГН-н менежментийн төлөвлөлтийн арга зүйн шинэчилсэн томьёоллоор excel өгөгдөл дээр боловсруулалт хийн жил тутамд шинэчлэгдэх тайлангийн дашбоард гаргах | | ✓ | ✓ |
| 32. Орон зайн мэдээллийн системийг нэгдсэн байдлаар нэг газраас давхаргын сервис хэлбэрээр дуудаж сайт дээр газрыг зурагт үзүүлэх | | ✓ | ✓ |
| **IV. Системийн хяналт, удирдлага** | | | |
| 9. Вебсайт болон гар утасны аппликэйшн тогтмол ажиллах | | ✓ | ✓ |
| 19. Цахим хуудсуудыг хайлтын системд /Google, Bing г.м/ илэрц өндөр байлгах холбосон байх тохиргоог хийх | | | ✓ |
| 23. ТХГН-ийн системийн нэгдсэн цахим хуудсанд ТХГН-уудын цахим хуудсуудын хандалт болон мэдээлэл шинэчлэлийн төлөвт мониторинг хийх боломжтой | | ✓ | ✓ |

| | | | |
|---|---|---|---|
| системтэйгээр хийх | | | |
| 24. Вебийн удирдлагын хэсэгт хэрэглэгчдийн хандах эрхийг динамикаар тохируулдаг байх | | | ✓ |
| 25. Вебийн удирдлагын хэсэгт бүртгэгдсэн мэдээллийг хянаж, мэдээллийн жагсаалтыг шаардлагатай утгаар шүүх мөн excel форматаар татаж авах, архивлах боломжтой болгох | | | ✓ |
| 26. Вебсайтад хандсан хандалт, зочны тоолууртай байх | | ✓ | |
| **V. Хүлээлгэн өгөх, сургалт** | | | |
| 7. Эдгээр цахим хуудсуудад материал оруулах админ нарт зориулсан гарын авлага боловсруулж, (цахим) сургалт зохион байгуулах | | | ✓ |
| 27. БОУАӨЯ-ны ТХГНБЗГ-ын цахим болон цаасан архивын нэгж үүсгэж актаар хүлээлгэн өгөх | | | ✓ |
| 28. Холбогдох бараа материалыг хүлээлгэн өгөх | | | ✓ |
| 34. ТХГН-н мэдээллүүд удирдлагын хэмжээнд хандах эрхийн хүрээгээр хязгаарлагдаж зөвхөн тухайн бүс нутгийн орон зайн болон хамаарал бүхий контент харагддаг байна | | | ✓ |

***Хүснэгт** 7. Хийгдэх ажлын жагсаал*

### 3.6 Тайлагнах хуваарь

- Эхний тайлан: БОУАӨЯ-ны ТХГНБЗГ баталгаажуулсан ажлын эхлэлийн тайлан, ажил гүйцэтгэх календарчилсан хуваарь, төлөвлөгөөг нэхэмжлэхийн хамт хүлээлгэж өгөх
- Эцсийн тайлан: БОУАӨЯ-ны ТХГНБЗГ баталгаажуулсан эцсийн тайланг холбогдох баримт бичгүүдийн хамт Захиалагчид хүлээлгэж өгч, сургалтын гарын авлагаар хангаж, сургалт зохион байгуулж, ажил хүлээлцсэн акт үйлдэх

### 3.7 Төлбөрийн хуваарь

- Эхний тайлан: Гэрээний үнийн дүнгийн 40% (дөчин хувь)
- Эцсийн тайлан: Гэрээний үнийн дүнгийн 60% (жаран хувь)

# 4. Зөвлөх үйлчилгээний гүйцэтгэл

### 4.1 Зөвлөх үйлчилгээ хэрэгжүүлэх уулзалтууд

Зөвлөх үйлчилгээний хүрээнд хэрэгжүүлэлттэй холбоотой захиалагч талтай 2024 оны 05 дугээр сарын 10, 2024 оны 11 дүгээр сарын 08, 2024 оны 12 дугээр сарын 02-ны өдрүүдэд нийт 3 удаагийн танхимын уулзалт хийсэн бөгөөд тус уулзалтаар вэб сайттай холбоотой заавар зөвлөмж өгөх болон нэмэлт засвар өөрчлөлтүүдийн талаар санал авсан болно. Уулзалт түс бүрээс гарсан санал шүүмжийг вэб сайтад тусган хөгжүүлэлтийг хийсэн.

1. Монгол орны ТХГН-ийн сүлжээний нэгдсэн цахим хуудсыг (www.mpa.gov.mn) орчин үеийн технологи ашиглан бүрэн шинэчилж, хэрэглэгчдэд ээлтэй интерфейстэй, аюулгүй, тогтвортой ажиллагаатай болгон хүлээлгэн өгсөн.
2. Нийт 41 хамгаалалттай газрын цахим хуудсыг нэгдсэн стандартын дагуу боловсруулж, Монгол болон Англи хэл дээр ажиллах боломжтой, хайлтын систем бүхий, мэдээллийн ил тод байдлыг хангасан байдлаар хөгжүүлж дуусгасан.
3. Системийг үр дүнтэй ашиглах талаар дэлгэрэнгүй сургалтын цахим гарын авлага боловсруулж, БОУАӨЯ-ны ТХГНБЗГ-ын мэргэжилтэн болон 41 ХЗ-ны асуудал хариуцсан мэргэжилтнүүдэд зориулсан цахим сургалтыг зохион байгуулсан тайланг хүлээлгэн өгсөн.
4. Төслийн хэрэгжилттэй холбоотой бүх мэдээ, баримт, тайланг хэвлэмэл болон Version Control System дээр байршуулсан цахим хуулбарын хамт бэлтгэж, системийн цаашдын хөгжүүлэлт, хэрэглээнд шаардлагатай бүх баримт бичгийг хүлээлгэн өгсөн.
5. БОУАӨЯ-ны ТХГНБЗГ-ын цахим болон цаасан архивын нэгжийг стандартын дагуу бүрдүүлж, системийн бүх баримт, кодын архивыг урт хугацааны хадгалалт, хамгаалалтын нөхцөлийг хангасан байдлаар хүлээлгэн өгсөн.
6. Төсөл хэрэгжүүлэх явцад ашигласан бүхий л бараа материалыг тооллого хийж, бүртгэлийн дагуу бүрэн бүрдэл, зөв ажиллагаатай эсэхийг шалгаж баталгаажуулсны үндсэн дээр захиалагч талд албан ёсоор хүлээлгэн өгсөн.

### 4.2 Ажлын даалгаварт тусгагдсан шаардлагууд болон хийх ажлын иж бүрдэл, түүний гүйцэтгэл

| № | Шаардлага | Хэрхэн гүйцэтгэх тухай ирүүлсэн санал | Тухайн ажлыг хэрхэн гүйцэтгэсэн тухай |
|---|---|---|---|
| **Хийх ажлын бүрдэл /Ерөнхий шаардлага/** | | | |
| 1 | Одоо ажиллаж буй ТХГН-ийн сүлжээний нэгдсэн цахим хуудас www.mpa.gov.mn-г шинэчилж технологи болон ашиглагдаж буй фреймворкийг хувилбар ахиулж сайжруулах | Одоо ажиллаж буй ТХГН-ийн веб системийн технологийн хувилбарыг шинэчлэх, хуучирсан фреймворкийг сүүлийн үеийн хувилбар руу шилжүүлэх шаардлагатай байсан. Мөн технологийн дэд бүтцийг цаашид тогтвортой ажиллах нөхцөлийг бүрдүүлэх, шаардлагатай тохиолдолд технологийг бүхэлд нь сольж шинэчлэх шаардлага тавигдсан. | • Хуучин фреймворкийг цаг үеийн шаардлагад нийцүүлэн хамгийн сүүлийн хувилбар луу шилжүүлсэн<br>• Зарим модуль, компонентуудын хуучирсан кодыг шинэчилсэн<br>• Систем дотор ашиглагдаж буй сангууд (libraries)-ийн хувилбарыг шинэчилсэн<br>• Аюулгүй байдлын эмзэг цэгүүдийг арилгасан<br>• Серверийн чадавхийг нэмэгдүүлсэн<br>• Системийн ерөнхий архитектурыг өөрчилж илүү оновчтой, хурдан болгосон<br>• Хандалтын хурдыг сайжруулсан |
| 2 | Монгол орны ТХГН-ийн сүлжээний нэгдсэн цахим хуудас болон 33 ХЗ-ны цахим хуудсуудыг динамик хэлбэрээр, түүнд мэдээлэл оруулах, хянан засварлах боломжтойгоор, эдгээрийг хийхэд онцгой ур чадвар | ТХГН-ийн нэгдсэн цахим хуудас болон 33 Хамгаалалтын Захиргаа (ХЗ)-ны цахим хуудсуудыг динамик хэлбэрээр хөгжүүлэх, мэдээлэл оруулах, хянах, засварлах үйл ажиллагааг тусгай мэргэжлийн ур чадваргүй хүн хийх боломжтой хялбар интерфейстэй байхаар хөгжүүлэх шаардлага тавигдсан | • Бүх цахим хуудсуудад динамик контент удирдлагын систем (CMS) бүрэн хөгжүүлэгдсэн<br>• Админ удирдлагын системийг хялбаршуулан, хэрэглэхэд хялбар интерфейс бүхий болгосон<br>• Мэдээлэл оруулах, засварлах, хянах процессыг хялбарчилсан<br>• WYSIWYG (What You See Is What You Get) редактор нэвтрүүлж, контент засварлахад хялбар болгосон |

| | | | |
|---|---|---|---|
| | шаардахгүй байхаар хийх | | ● Хэрэглэгчийн гарын авлага боловсруулж, админ хэсэгт байршуулсан<br>● Админ хэсгийн талаар сургалт зохион байгуулж, хэрэглэгчдийг бүрэн бэлтгэсэн<br>33 ХЗ-ны бүх цахим хуудсуудыг динамик контент удирдлагын системтэй болгосон |
| 3 | Нэмэлтээр 8 ХЗ-ны цахим хуудсыг нэгдсэн стандартын дагуу боловсруулах | Шинээр нэмэгдсэн 8 Хамгаалалтын Захиргааны цахим хуудсыг нэгдсэн стандартын дагуу боловсруулж, бусад цахим хуудастай ижил түвшинд хөгжүүлэх шаардлага тавигдсан. Энэ нь ТХГН-ийн бүх цахим хуудсуудыг нэгдсэн стандартаар, ижил хэрэглэгчийн туршлага, функционал, загвартай байлгах зорилготой. | ● Нэмэгдэж үүссэн 8 ХЗ-ны цахим хуудсыг бусад 33 ХЗ-тай ижил нэгдсэн стандартаар хөгжүүлж дуусгасан<br>● Бүх 41 ХЗ-ны цахим хуудас нэг системийн хүрээнд ажиллах боломжтой болсон<br>● Нэмэлт 8 ХЗ-ны цахим хуудсуудад мэдээлэл оруулах, засварлах, хянах боломжийг бүрдүүлсэн<br>● Шинээр нэмэгдсэн ХЗ-дын онцлогт тааруулан тохируулалт хийсэн<br>● Мэдээллийн сангуудтай холбож, мэдээлэл солилцох боломжийг бүрдүүлсэн<br>● Аюулгүй байдал, нэвтрэх эрхийн хязгаарлалтыг тохируулсан |
| 4 | Монгол орны ТХГН-ийн сүлжээний нэгдсэн цахим хуудас нь 41 ХЗ, олон улсын байгууллагуудын болон тэдгээрийн хэрэгжүүлж буй | ТХГН-ийн нэгдсэн цахим хуудас (mpa.gov.mn) нь 41 Хамгаалалтын Захиргаа, түүнчлэн олон улсын байгууллагууд болон тэдгээрийн хэрэгжүүлж буй төсөл, | ● Бүх 41 ХЗ-ны цахим хуудсуудыг нэгдсэн цахим хуудастай холбосон<br>● Олон улсын байгууллагууд (WWF, GIZ, UNDP, TNC гэх мэт)-ын цахим хуудсуудтай холбоос үүсгэсэн<br>● Тэдгээрийн хэрэгжүүлж буй төсөл, хөтөлбөрүүдийн |

| | | | |
|---|---|---|---|
| | төсөл, хөтөлбөрүүдийн цахим хуудсуудтай холбогдсон байх | хөтөлбөрүүдийн цахим хуудсуудтай холбогдсон байхаар хөгжүүлэх шаардлага тавигдсан. Энэ нь мэдээллийн урсгал, солилцоог сайжруулах, холбогдох бүх байгууллагуудын үйл ажиллагааг нэгтгэн харуулах зорилготой. | мэдээллийг ТХГН-ийн захиргаадтай холбож харуулах боломжтой болгосон<br>● Холбоосуудыг хэрэглэгчдэд ойлгомжтой, хүртээмжтэй байдлаар зохион байгуулсан<br>● Цахим хуудсуудын хооронд мэдээлэл солилцох API (Application Programming Interface) хөгжүүлсэн<br>● Холбогдсон бүх системүүдээс мэдээллийг нэгтгэн харуулах боломжийг бүрдүүлсэн |
| 5 | Монгол орны ТХГН-ийн сүлжээний нэгдсэн цахим хуудас болон 41 ХЗ-ны цахим хуудасны домайн нэр, түүний эрх, багадаа 5 и-мэйл хаягтай байх | ТХГН-ийн нэгдсэн цахим хуудас болон 41 ХЗ-ны цахим хуудас нь өөрийн гэсэн домэйн нэртэй байх, эдгээр домэйн нэр, тэдгээрийн эрх, мөн дор хаяж 5 имэйл хаягийг бий болгох шаардлага тавигдсан. Энэ нь цахим орчинд ТХГН-ийн байгууллагуудын албан ёсны оролцоо, танигдах байдлыг дээшлүүлэх, мэргэжлийн харилцаа холбоог хангах зорилготой. | ● Нэгдсэн систем (mpa.gov.mn) болон 41 ХЗ-ны хувьд тус тусдаа домэйн болон субдомэйнүүдийг үүсгэсэн<br>● Жишээ нь: khuvsgul.mpa.gov.mn, khangai.mpa.gov.mn гэх мэт<br>● Домэйн нэрийг үүсгэсний дараа систем дээр шууд бүртгэл үүсгэн холбох боломжтой болгосон<br>● Яамны зүгээс имэйл хаягуудыг үүсгэх өгөх бөгөөд яамны мэдээлэл технологийн ажилтантай холбогдож яамны үүсгэх боломжтой байгаа талаар ажлын гүйцэтгэлийн уулзалт дээр танилцуулагдсан<br>● Домэйн нэрийн серверийн тохиргоо, аюулгүй байдлыг хангасан<br>● Домэйны удирдлагыг нэгдсэн байдлаар шийдвэрлэсэн |

| | | | |
|---|---|---|---|
| | | | ● Домэйн нэр, имэйл хаягуудын удирдлагын гарын авлага боловсруулсан |
| 6 | Бүх цахим хуудсууд нь Монгол, Англи хэл дээр хийгдэх /шаардлагатай орчуулгыг админ хэсгээс буюу зөвлөх байгууллагаас хамааралгүй засварлах боломжтой байх/ | Нэгдсэн цахим хуудас болон 41 ХЗ-ны цахим хуудсууд нь Монгол, Англи хэл дээр ажиллах боломжтой байх, мөн орчуулгыг зөвлөх байгууллагаас хамааралгүйгээр админ хэсгээс засварлах боломжтой байх шаардлага тавигдсан. Энэ нь олон улсын хэрэглэгчдэд мэдээллийг хүргэх, олон хэл дээр ажиллах уян хатан боломжийг бүрдүүлэх зорилготой. | ● Цахим хуудсуудыг олон хэл дэмжих модультай болгосон<br>● Супер админ эрхээр орж орчуулгыг засах, нэмэх боломжтой болгосон<br>● Монгол, Англи хэлний хувилбарууд бүрэн ажиллагаатай болсон<br>● Статик болон динамик агуулгын орчуулгын боломжийг бүрдүүлсэн<br>● Орчуулгын файлуудыг удирдах, шинэчлэх, импортлох, экспортлох боломжтой болгосон<br>● Хэлний сонголтыг хадгалах, хэрэглэгчийн тохиргоог санах боломжтой болгосон<br>● Хэлний модуль шаардлагатай үед бусад хэлийг нэмэх боломжтой архитектуртай болгосон |
| 7 | Эдгээр цахим хуудсуудад материал оруулах админ нарт зориулсан гарын авлага боловсруулж, (цахим) сургалт зохион байгуулах | Цахим хуудсудын админ хэрэглэгчдэд зориулсан дэлгэрэнгүй гарын авлага боловсруулах, мөн цахим сургалт зохион байгуулж хэрэглэгчдийг бэлтгэх шаардлага тавигдсан. Энэ нь системийг үр дүнтэй ашиглах, хэрэглэгчдийг бэлтгэх, мэдээллийг оновчтой засварлах, оруулах | ● Гарын авлагыг цахим хэлбэрээр бэлдэж админ удирдлагын хэсэгт байршуулсан<br>● Гарын авлагад дараах бүлгүүд багтсан:<br>○ Системд нэвтрэх<br>○ Мэдээлэл оруулах, засварлах, устгах<br>○ Файл, зураг, видео оруулах<br>○ Хэрэглэгчдийн эрх, зөвшөөрөл тохируулах |

| | | | |
|---|---|---|---|
| | | чадавхыг бүрдүүлэх зорилготой. | ○ Нийтлэг асуудлуудын шийдэл<br>● Цахим сургалтуудыг төлөвлөгөөний дагуу зохион байгуулсан<br>● Танхимын сургалтуудыг зохион байгуулж, хэрэглэгчдийг бэлтгэсэн<br>● Цахим сургалтын видео бичлэгүүд хийж, системд байршуулсан<br>● Сургалтын материалуудыг тогтмол шинэчлэх, хадгалах боломжтой болгосон<br>● Гарын авлагыг хэвлэмэл болон цахим хэлбэрээр бэлтгэсэн |
| 8 | EIC.mn сервер дээр байршиж буй БИОСАН зэрлэг амьтан, ургамлын мониторингийн мэдээллийн сангийн серверийг одоогийн хөгжүүлж буй сервер рүү шилжүүлэх, гар утасны аппликэйшнаар дамжин цугларч буй дата мэдээлэл тогтвортой найдвартай ажиллагааг хангах тухайд ТХГН-ийн сүлжээний | EIC.mn сервер дээр байршиж буй БИОСАН зэрлэг амьтан, ургамлын мониторингийн мэдээллийн сангийн серверийг шинэ сервер рүү шилжүүлэх, гар утасны аппликэйшнаар цуглуулж буй мэдээллийн тогтвортой, найдвартай ажиллагааг хангах технологийн шийдэл боловсруулах шаардлага тавигдсан. Энэ нь ТХГН-ийн системүүдийн интеграци, мэдээллийн | ● БИОСАН-ийн серверийг шинэ серверт амжилттай шилжүүлсэн<br>● Шилжүүлэлтийн явцад бүх мэдээллийн бүрэн бүтэн байдлыг хангасан<br>● Мэдээллийн санг боловсруулж, дашбоардаар харуулах боломжтой болгосон<br>● Гар утасны аппликэйшноос цуглуулсан мэдээллийг найдвартай хадгалах технологийн шийдлийг боловсруулсан<br>● API интерфейс хөгжүүлж, гар утасны аппликэйшнтай мэдээлэл солилцох боломжийг бүрдүүлсэн<br>● Хэрэглэгчийн эрх, аюулгүй байдлын тохиргоог шинэчилсэн |

| | | | |
|---|---|---|---|
| | цахим системийн технологи шийдэл гаргах | нэгдмэл байдлыг хангах зорилготой. | ● Мэдээллийн нөөцлөлт, сэргээлтийн систем нэвтрүүлсэн |
| 9 | Вэбсайт болон гар утасны аппликэйшн тогтмол ажиллах | Вэб сайт болон гар утасны аппликэйшн тогтмол, найдвартай ажиллах нөхцөлийг бүрдүүлэх шаардлага тавигдсан. Энэ нь хэрэглэгчдэд үйлчилгээг тасралтгүй, найдвартай хүргэх зорилготой. | ● Веб сайтын тогтвортой ажиллагааг хангах серверийн дэвшилтэт тохиргоо хийсэн<br>● Ачаалал даах чадварыг сайжруулж, нэг зэрэг 1000+ хэрэглэгч хандах боломжийг бүрдүүлсэн<br>● Хэрэглэгчийн интерфейсийг оновчлон, хуудасны ачаалалт хурдыг 3 дахин сайжруулсан<br>● Серверийн ачаалал, гүйцэтгэлийг хянах мониторингийн систем нэвтрүүлсэн<br>● Аюулгүй байдлын тохиргоо, файрволын тохиргоог оновчлон хийсэн<br>● Вэбсайтын нөөц хуулбар үүсгэх автомат системийг тохируулсан<br>● 2024 оны 05 дугаар сарын 10-ны өдөр хийгдсэн гэрээ байгуулахын өмнөх хурлаар гэрээний үнийн дүнд гар утасны аппликейшн хийнэ гэсэн дүн ороогүй учраас гар утасны аппликейшн хийгдэхгүй гэж тохиролцсон. |
| 10 | БИОСАН-гийн дашбоард олон нийтэд харагдаж байх, харагдахдаа Монгол улсын | БИОСАН-гийн дашбоардыг олон нийтэд харагдахаар хийх, Монгол улсын хэмжээнд хаана ашиглагдаж байгааг | ● БИОСАН-гийн дашбоардыг олон нийтэд харагдахаар хөгжүүлсэн<br>● EIC-с ирж буй мэдээллийг орон зайн хэлбэрээр олон |

| | | | |
|---|---|---|---|
| | хэмжээнд хаана хаана хэрэглэгдэж байгаа харагдах, мөн тусгай хамгаалалттай газрын ангилал бүрээр харьцуулан харагдах | харуулах, тусгай хамгаалалттай газрын ангилал бүрээр харьцуулан харуулах боломжтой байх шаардлага тавигдсан. Энэ нь БИОСАН-гийн мэдээллийг олон нийтэд хүртээмжтэй болгох, шийдвэр гаргалтанд дэмжлэг үзүүлэх зорилготой. | нийтэд харуулах боломжтой болгосон<br>● Монгол улсын хэмжээнд хаана хэрэглэгдэж байгааг газрын зургаар харуулсан<br>● Тусгай хамгаалалттай газрын ангилал бүрээр (Байгалийн цогцолборт газар, Байгалийн нөөц газар, Дархан цаазат газар, Дурсгалт газар) харьцуулан харах боломжийг бүрдүүлсэн<br>● Статистик мэдээлэл, харьцуулсан судалгааг харуулахын тулд график, диаграм зэргийг ашигласан<br>● Шүүлтүүр тавьж, хэрэглэгчийн хэрэгцээнд тохирсон мэдээлэл харах боломжтой болгосон<br>● Тодорхой хугацааны интервалаар мэдээллийг харах боломжтой болгосон |
| 11 | СМАRT-ын дашбоард олон нийтэд харагдаж байх, Монгол улсын хэмжээнд хаана хаана хэрэглэгдэж байгаа харах, мөн тусгай хамгаалалттай газрын ангилал бүрээр харьцуулан харагддаг байх | СМАRT-ын дашбоардыг олон нийтэд харагдахаар хийх, Монгол улсын хэмжээнд хаана ашиглагдаж байгааг харуулах, тусгай хамгаалалттай газрын ангилал бүрээр харьцуулан харуулах боломжтой байх шаардлага тавигдсан. Энэ нь СМАRT системийн мэдээллийг олон нийтэд хүртээмжтэй болгох, шийдвэр гаргалтанд | |

| | | | |
|---|---|---|---|
| | | дэмжлэг үзүүлэх зорилготой. | |
| 12 | ТХГН-ийн менежментийн үр ашигт байдлын үнэлгээний дашбоард олон нийтэд харагдаж байх, ТХГН тус бүрээр он оноор харьцуулан харагдах | ТХГН-ийн менежментийн үр ашигт байдлын үнэлгээний дашбоардыг олон нийтэд харагдахаар хийх, ТХГН тус бүрээр он оноор харьцуулан харагдах боломжтой байх шаардлага тавигдсан. Энэ нь менежментийн үр дүнг тодорхойлох, харьцуулах, шийдвэр гаргалтад дэмжлэг үзүүлэх зорилготой. | ● Биосангийн сайтаас мэдээлэл татаж тайлан хэлбэрээр админ хэсэгт харуулах боломжтой болгосон<br>● Менежментийн үр ашигт байдлын үнэлгээний дашбоардыг хөгжүүлсэн<br>● ТХГН тус бүрээр он оноор харьцуулан харах боломжтой болгосон<br>● Дашбоардад олон төрлийн графикууд (цагийн муруй, баганан диаграм, radar chart гэх мэт) ашигласан<br>● Дашбоардын тайлангийн мэдээллийг ангилал, бүс нутаг, он цагаар шүүх боломжтой болгосон<br>● Зурган болон excel форматаар тайланг татаж авах боломжтой болгосон<br>● Биосангийн мэдээллийг ашиглан тайлан хэлбэрээр харуулах боломжтой болгосон |

| | | | |
|---|---|---|---|
| 13 | Орон зайн /Газрын зураг/ мэдээллийг оруулж олон нийтэд ойлгомжтой хүртээмжтэй харагддаг байх | Орон зайн (газрын зураг) мэдээллийг цахим хуудаст оруулж, олон нийтэд ойлгомжтой, хүртээмжтэй хэлбэрээр харуулах шаардлага тавигдсан. Энэ нь ТХГН-ийн орон зайн мэдээллийг олон нийтэд ойлгомжтой болгох, байршлыг тодорхой харуулах зорилготой. | ● Газрын зураг гэсэн тусдаа хуудас гаргасан бөгөөд тухайн хуудсан дээр EIC-н орон зайн мэдээллийн давхаргын сервисийг ашиглаж харуулж байгаа<br>● Интерактив газрын зураг хөгжүүлсэн (томруулах, жижигрүүлэх, чирэх, давхаргууд нээх, хаах гэх мэт)<br>● ТХГН-ийн бүх хилийн заагуудыг газрын зураг дээр харуулсан<br>● Хайлтын системийг нэвтрүүлж, газрын зураг дээр ТХГН-ийг нэрээр хайх боломжтой болгосон<br>● Газрын зураг дээр байршлаар шүүх, харьцуулах боломжтой болгосон<br>● Олон нийтэд ойлгомжтой, хэрэглэхэд хялбар интерфейсийг хөгжүүлсэн<br>● Мэдээллийн давхаргуудыг сонгох, хоорондоо давхцуулах боломжтой болгосон |
| 14 | Орон зайн мэдээллийг баяжуулж харагдах давхарга болон бусад мэдээллийг харах боломжийг олгох | Орон зайн мэдээллийг баяжуулж, давхаргуудаар харах, бусад холбогдох мэдээллийг нэмж харах боломжтой болгох шаардлага тавигдсан. Энэ нь хэрэглэгчдэд илүү дэлгэрэнгүй, баялаг мэдээллийг үзүүлэх, | ● EIC-н орон зайн мэдээллийн давхаргын сервисийг ашиглаж харуулахаас гадна ТХГН-н өөрсдийн сайт дээр аяллын маршрут зэрэг орон зайн мэдээллийг харуулж байгаа<br>● Дараах мэдээллийн давхаргуудыг орон зайн мэдээлэлд нэмж оруулсан: |

| | | | |
|---|---|---|---|
| | | тэдний хэрэгцээнд нийцсэн орон зайн мэдээллийг харуулах зорилготой. | ○ ТХГН-ийн ангилал (Байгалийн цогцолборт газар, Байгалийн нөөц газар, Дархан цаазат газар, Дурсгалт газар)<br>○ Аяллын маршрут, замууд<br>○ Амралт, аялал жуулчлалын газрууд<br>○ Ховор, нэн ховор амьтад, ургамлын тархалт<br>○ Голлох дэд бүтцийн объектууд (зам, гүүр, барилга байгууламж)<br>○ Байгалийн үзмэрүүд<br>● Давхаргуудыг сонгож, хослуулан харах боломжтой болгосон<br>● Мэдээллийг баяжуулах, шинэчлэх боломжийг бүрдүүлсэн<br>● Хэрэглэгчийн сонгосон давхаргуудын хослолыг хадгалах боломжтой болгосон<br>● Орон зайн мэдээллийг гаргалгаажуулах боломжтой болгосон |
| 15 | ТХГН-т хийх аялал жуулчлал болон үйл явдлын мэдээллийг олон нийтэд хүртээмжтэй байдлаар зохиомжлон | ТХГН-т хийх аялал жуулчлал болон үйл явдлын мэдээллийг олон нийтэд хүртээмжтэй байдлаар зохиомжлон цахим хуудсанд оруулах боломжтой болгох шаардлага тавигдсан. Энэ нь аялал | ● Эвент, аяллын маршрут зэрэг мэдээллийг оруулах боломжоор хангаж сайт дээр зохиомжлон оруулсан<br>● Аялал жуулчлалын мэдээллийн бүтцийг дараах байдлаар зохион байгуулсан:<br>○ Аяллын маршрутууд (зураг, тайлбар, |

| | | | |
|---|---|---|---|
| | цахим хуудсанд оруулах | жуулчлалыг дэмжих, ТХГН-ийн үйл ажиллагааг сурталчлах, олон нийтийн оролцоог нэмэгдүүлэх зорилготой. | үргэлжлэх хугацаа, хүндрэлийн зэрэг)<br>○ Жуулчдын байр, амралтын газрууд<br>○ Үзмэрүүд, үзэх газрууд<br>○ Зөвлөмжүүд, аюулгүй байдлын мэдээлэл<br>● Үйл явдлын мэдээллийг календарь хэлбэрээр харуулсан<br>● Аялал жуулчлалын хуудсыг дизайны хувьд таталцуулан хийсэн<br>● Зураг, видео галерей нэвтрүүлсэн |
| 16 | ТХГН-н удирдлага өөрсдийн цахим хуудсанд жуулчлал, тухайн газар болох эвент, үйл явдлын мэдээллийг нийтлэх боломжтой болгох мөн олон нийтэд харуулах буланг шинээр хийж оруулах | ТХГН-ийн удирдлагууд өөрсдийн цахим хуудсанд жуулчлал, тухайн газар болох эвент, үйл явдлын мэдээллийг нийтлэх боломжтой болгох, мөн олон нийтэд харуулах буланг шинээр хийж оруулах шаардлага тавигдсан. Энэ нь ТХГН-ийн удирдлагуудад мэдээллээ шууд удирдах, шинэчлэх боломжийг олгох зорилготой. | ● ТХГН удирдлага сайт дээрхи бүх контентоо өөрсдөө удирдах бөгөөд эвент, үйл явдлын цэсийг шинээр хөгжүүлсэн<br>● ТХГН-ийн удирдлагууд дараах мэдээллийг оруулах, засварлах боломжтой болгосон:<br>○ Үйл явдал, арга хэмжээний мэдээлэл (огноо, цаг, байршил, тайлбар, хамрах хүрээ)<br>○ Аяллын маршрутын мэдээлэл (зураг, тайлбар, аяллын онцлог, давуу тал)<br>○ Байршлын мэдээлэл (газрын зураг, координат, хүрэх зам)<br>○ Үзэх зүйлс, үзмэрүүдийн мэдээлэл<br>○ Байрлах газрын мэдээлэл |

| | | | |
|---|---|---|---|
| | | | • Олон нийтэд харуулах буланг шинээр хийж оруулсан (мэдээ, мэдээлэл, зарлал, анонс)<br>• Мэдээллийн ангилал, шүүлтүүрийг боловсронгуй болгосон<br>• Аялал жуулчлалын мэдээллийг тогтмол шинэчлэх боломжтой болгосон<br>• Мэдээллийг хянах, баталгаажуулах процессыг нэвтрүүлсэн |
| 17 | Системийн UX талыг сайжруулах үүднээс /Angular, React, Vue/ гэх мэт Frontend framework-уудын аль нэгийг ашиглан SEO-д харшлахгүйгээр хэрэгцээтэй модулиуд дээр SPA /Single Page Application/ хэлбэрээр ажилладаг байх | Системийн хэрэглэгчийн туршлага (UX)-ийг сайжруулах үүднээс Angular, React, Vue зэрэг Frontend framework-уудын аль нэгийг ашиглан SEO-д харшлахгүйгээр хэрэгцээтэй модулиуд дээр SPA (Single Page Application) хэлбэрээр ажилладаг байхаар хөгжүүлэх шаардлага тавигдсан. Энэ нь хэрэглэгчийн туршлагыг сайжруулах, системийн ажиллагааг хурдасгах, орчин үеийн веб технологийг нэвтрүүлэх зорилготой. | • Үндсэн сайт дээрээ Front-End талдаа загвар сайжруулалт хийн орчин үеийн фреймворк болох VueJS ашиглан хийсэн<br>• SEO-д харшлахгүйгээр SPA (Single Page Application) хэлбэрээр ажиллах боломжтой болгосон - Server Side Rendering (SSR) ашигласан<br>• Хурдан ачаалагдах, тасралтгүй ажиллагааг хангасан<br>• Дараах модулиудыг SPA хэлбэрээр хөгжүүлсэн:<br>  ○ Газрын зургийн мэдээллийн систем<br>  ○ Аялал жуулчлалын модуль<br>  ○ Хайлтын систем<br>  ○ Дашбоардууд<br>  ○ Мэдээ, мэдээллийн хэсэг<br>  ○ Админ удирдлагын хэсэг |

| | | | |
|---|---|---|---|
| | | | ● Компонент-ориентед архитектур нэвтрүүлсэн<br>● Хэрэглэгчийн туршлагыг (UX) эрс сайжруулсан<br>● Responsive дизайн, гар утас, таблет, компьютерын дэлгэцийн хэмжээнд тохирох загвар хийсэн |
| 18 | Цахим хуудас дотор хайлтын системтэй байх | Цахим хуудас дотор үр дүнтэй хайлтын системтэй байх, хэрэглэгчид шаардлагатай мэдээллээ хялбар, хурдан олох боломжтой байхаар хөгжүүлэх шаардлага тавигдсан. Энэ нь хэрэглэгчдэд мэдээллийг хурдан, үр дүнтэй олоход туслах зорилготой. | ● Дотоод хайлтын системээр цаг үеийн мэдээ, эвент зэрэг контентуудаас шүүж харах боломжтой болгосон<br>● Хайлтын системийн боломжууд:<br>○ Бүх төрлийн контентоос хайх (мэдээ, эвент, аяллын маршрут, үзмэр, бүх хуудас)<br>○ Категориор шүүх (ТХГН-ийн төрөл, бүс нутаг, контентын төрөл)<br>○ Огноогоор шүүх (тодорхой хугацааны интервалаар)<br>○ Түлхүүр үгээр хайх<br>○ Хайлтын үр дүнг эрэмбэлэх (огноо, холбогдох байдал)<br>● Хайлтын үр дүнг ангилал, төрлөөр нь харуулах боломжтой болгосон<br>● Авто санал болгох функц нэвтрүүлсэн (хэрэглэгч текст бичиж эхлэхэд санал болгодог)<br>● Алдаатай бичилтийг залруулж хайх боломжтой болгосон |

| | | | |
|---|---|---|---|
| | | | ● Хайлтын индексийг тогтмол шинэчлэх автомат процесс нэвтрүүлсэн<br>● Хайлтын систем нь хэрэглэхэд хялбар, үр дүнтэй ажиллагаатай болсон |
| 19 | Цахим хуудсуудыг хайлтын системд /Google, Bing г.м/ илэрц өндөр байлгах холбосон байх тохиргоог хийх | Цахим хуудсуудыг хайлтын системд (Google, Bing гэх мэт) илэрц өндөр байлгах тохиргоо, холболтыг хийх, SEO оновчлолыг хийх шаардлага тавигдсан. Энэ нь цахим хуудсын хандалтыг нэмэгдүүлэх, олон нийтэд хүрэх хүрээг өргөжүүлэх зорилготой. | ● Мета өгөгдөл болон тагуудтай ажиллаж хайлтын бот-д тааруулж хийсэн<br>● Google, Bing зэрэг хайлтын системд бүртгэж, хайлтын индексд оруулсан<br>● Дараах SEO оновчлолууд хийгдсэн:<br>○ Мета тагууд (title, description, keywords)<br>○ Canonical URL-үүд<br>○ Open Graph тагууд (Facebook, Twitter)<br>○ Structured data (schema.org)<br>○ Хуудсууд дахь гарчиг (H1, H2, H3) тагуудын оновчлол<br>○ Зургуудын ALT тагууд<br>○ Холбоосуудын оновчлол<br>● Robots.txt файл үүсгэж тохируулсан<br>● Google Search Console, Bing Webmaster Tools-д бүртгэж, мониторинг хийх боломжтой болгосон<br>● SEO оновчлол хийж, түлхүүр үгүүдээр хайхад илэрц өндөр байхаар тохируулсан |

| | | | |
|---|---|---|---|
| 20 | Цахим хуудсууд нь фото зураг, видео болон аудио бичлэг оруулах, хадгалах хэсэгтэй байх | Цахим хуудсуудад фото зураг, видео болон аудио бичлэг оруулах, хадгалах боломжтой байх, мультимедиа контентыг бүрэн дэмжсэн байх шаардлага тавигдсан. Энэ нь контентыг илүү сонирхолтой, баялаг болгох, аудио-визуал мэдээллийг хүргэх зорилготой. | ● Төрөл бүрийн өргөтгөлтэй файл хавсаргах боломжтой болгосон<br>● Дэмжигдсэн файлын форматууд:<br>○ Зураг: JPEG, PNG, GIF, SVG, WEBP<br>○ Видео: MP4, WEBM<br>○ Аудио: MP3<br>● Фото зургийн галерей үүсгэх, зохион байгуулах боломжтой болгосон<br>● Видео, аудио бичлэгүүдийг оруулах, тоглуулах функцийг бүрэн хөгжүүлсэн<br>● Зургийн хэмжээг автоматаар тохируулах боломжтой болгосон<br>● Видео контентыг YouTube зэрэг платформуудаас оруулах боломжтой болгосон<br>● Файлуудыг албан ёсны категориор ангилах боломжтой болгосон<br>● Хавсралтуудын хэмжээ, төрлийг хязгаарлах, хянах боломжтой болгосон<br>● Мультимедиа контентыг хайх, шүүх боломжтой болгосон<br>● Файлын менежментийн систем нэвтрүүлж, файлуудыг дахин ашиглах боломжтой болгосон<br>● Файлыг он сарын дараааллаар вэб дээр архив хэлбэрээр үүсэхээр зохион байгуулсан |

| | | | |
|---|---|---|---|
| 21 | Цахим хуудсанд нийтлэгдсэн контентыг олон нийтийн сүлжээнд мэдээллийг хуваалцах болон түгээх боломжтой байх | Цахим хуудсанд нийтлэгдсэн контентыг олон нийтийн сүлжээнд хуваалцах, түгээх боломжтой байхаар хөгжүүлэх шаардлага тавигдсан. Энэ нь цахим хуудсын контентыг олон нийтийн сүлжээгээр дамжуулан түгээх, хүрэх хүрээг өргөжүүлэх зорилготой. | ● Мета өгөгдлийг сошиал сүлжээний шаардлагын дагуу үүсгэж цаг үеийн мэдээлэл зэргийг хуваалцах боломжтой болгосон<br>● Дараах олон нийтийн сүлжээнд хуваалцах боломжтой болгосон:<br>○ Facebook<br>○ Twitter/X<br>● Open Graph мета тагууд нэвтрүүлж, олон нийтийн сүлжээнд контент хуваалцахад зураг, гарчиг, тайлбар зөв харагдах боломжтой болгосон<br>● Контент бүрийн доор хуваалцах товчлууруud нэмсэн<br>● Олон нийтийн сүлжээний дагалтуудын тоог харуулах виджет нэвтрүүлсэн<br>● Хуваалцсан агуулга нь зөв форматтай, preview зурагтай харагддаг байхаар оновчилсон |
